



Монгол Улсын Үндэсний номын сангийн “Авлигатай тэмцэх жил” 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохион байгуулах ажлын чиглэл	Биелэлт
1	АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн 110 самбарт байршуулж олон нийтэд хүргэх	- АТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу ХАСХОМ шинэчлэн гаргах тухай сурталчилгааны доорхи линкийг өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудсаар мэдүүлэг гаргагч нарт зориулан түгээж ажилласан. - Авлигын эсрэг соён гэгээрүүлэх аяны үйл ажиллагаатай холбоотойгоор байгууллагын веб сайт, фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлах, фэйсбүүк хуудасны cover зургийг Нэгдье аяны логогоор сольж, пост оруулж, вебсайтад холбогдох мэдээг оруулсан.  
2	“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэх	Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 2023 оны 03 дугаар сард мэдээллийн 110 самбарт гарын авлага, танилцуулга, материалыг шинэчлэх, баяжуулах материал авах хүсэлтийг хүргүүлсэн.

		“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” буланд өөрсдийн нөөц бололцооны хүрээнд 60 ширхэг гарын авлагыг хуулбарлан байршуулж мэдээллийг баяжуулсан.
3	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 2023 оны 03 дугаар сард албан бичгээр нийт албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авах хүсэлтийг хүргүүлсэн. Тус хэлтсээс Соёлын яамны салбарын албан хаагчдын дунд зохион байгуулах сургалтад холбогдох албан хаагчдаа хамруулах чиглэлийг /88223309/ утсаар өгсөн. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Соёлын яамны харьяа байгууллагын удирдлагууд, ЭБАТ-уудад /Эрх бүхий албан тушаалтнууд/ 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан сургалт, уулзалтад холбогдох албан хаагчид оролцсон. АТГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Соёлын яамнаас Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёлын яамны болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй харьяа байгууллагын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан хаагчдад зориулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчийн ёс зүй, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан ба тус сургалтад нийт 6 хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч, ЭБАТ нийт 8 албан хаагч танхимаар бүрэн хамрагдсан. ХЗДХэргийн Сайдын 2023.05.05-ны өдрийн 1/2560 албан бичгээр ирсэн мэдээллийн дагуу 2023.05.12-ны өдөр Төрийн ордны их танхимд БНСУ-ын Хууль тогтоомжийн сайд асан Ли Сөг Ёний уншсан “Авлигатай тэмцэх тухай” лекцэд ЭБАТ Д.Мөнхгэрэл хамрагдсан.
4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан нь тогтоогдсон тохиолдолд холбогдох албан	2023 оны эхний хагас жилд Авлигатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй болно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд

	тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах	заасны дагуу нийт 130 хуудас бүхий 65 мэдэгдлийг гарган шилэн дансанд байршуулсан.
5	Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчид танилцуулах	2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан МУҮНС-гийн Захирлын 2023 оны 03 дугаар сарын 15-ны А/15 тоот тушаалаар баталсан.

Тайлан гаргасан: МУҮНС-гийн Эрх бүхий албан тушаалтан, Хүний нөөцийн ажилтан Д.Мөнхгэрэл
2023.06.15